



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

Г Г

Тушаалын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 5.2, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны үндсэн чиг үүргийг болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн "Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай" 30 дугаар тушаалын 1,2,4 дүгээр хавсралтаар баталсан "Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүн", "Хүний эмийн зөвлөлийн мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн", "Хүний эмийн зөвлөлийн мэргэжлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д дор дурдсан нэмэлт өөрчлөлт оруулсугай.
- "Хүний эмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн эмийн сонголт, бүртгэл, эмнэлзүйн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн" гэж, Хүний эмийн зөвлөлийн биологийн идэвхит бүтээгдэхүүний салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн" гэж, Хүний эмийн зөвлөлийн эмзүйн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн" гэж, Хүний эмийн зөвлөлийн эм судлалын салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмийн зохицуулалтын албаны тандалт судалгаа хариуцсан мэргэжилтэн" гэж тус тус өөрчлөх,
- журмын 3.2.6 дахь хэсэгт "Улсын бүртгэлд бүртгэгдсэн биологийн идэвхит бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгыг хянаж, баталгаажуулах" гэж нэмэх,
- журмын 3.4.2 дахь хэсгээс "...биологийн идэвхт бүтээгдэхүүний..." гэснийг хасах.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний эмийн зөвлөл /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА



A handwritten signature in black ink, reading "Г.ШИЙЛЭГДАМБА", placed over the red stamp.